



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 11 өдөр

Дугаар А/1280

Улаанбаатар хот

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулсантай холбогдуулан хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.в, 29.1.6.ж, л, 29.2, 39 дүгээр зүйл, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11, 17 дугаар зүйл, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.5 дахь хэсэг, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэргийг бууруулах тухай" 209 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 06.00 цагаас шилжүүлсэнтэй холбогдуулан хязгаарлалтыг хэвээр үргэлжлүүлэх үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан "Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр заавар", "Зарим үйлчилгээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага"-ын хэрэгжилтийг удирдлагаар хангаж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Т.Гантөмөр/, хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хавсралтад зааснаас бусад худалдаа, үйлчилгээний газруудын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг 07:00-22:00 цаг хүртэл хугацаагаар тогтоож, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдэд спиртийн өндөр агууламж /18 хувиас дээш/ бүхий согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглосугай.

4. Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг түр хаасан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, харгалзах хүнгүй, гэртээ үлдсэн хүүхдүүдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сургалтын хөтөлбөрийн дагуу теле хичээл, цахим сургалтыг зохион байгуулж ажиллахыг нийслэлийн Боловсролын газар /Ж.Гантулга/, нийслэлийн Нийгмийн халамжийн газар /Д.Мөнхбаяр/, нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар /Ө.Ган-Өлзий/-т үүрэг болгосугай.

5. Томуу, томуу төст өвчний тархалт болон коронавируст /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх, эрүүл мэндийн салбарын хүчин чадал, нөөцийн судалгааг дахин тодорхойлж, хүн хүчний нөөц бүрдүүлэх, эрсдэлийг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, яаралтай тусламжийн болон байнгын бэлэн байдлыг хангаж ажиллахыг нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/-т үүрэг болгосугай.

111020006311

6. “Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг QR код ашиглан бүртгэх систем”-ийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад нэвтрүүлэн дагаж мөрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан, хэрэгжүүлж ажиллахыг нийслэлийн Мэдээлэл, технологийн газар /О.Чинзориг/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

7. Халдварын тохиолдол бүртгэгдсэн хороо, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн ажиллах горим, үйл ажиллагааны чиглэл, иргэдийн хөдөлгөөний хүрээ, хязгаарыг тогтоож, халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг мөрдүүлж ажиллахыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Улаанбаатар хотын авто тээврийн шалган нэвтрэх товчоодоор орж гарч байгаа зорчигчдын халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг чанд мөрдүүлж ажиллахыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар /Л.Эрдэнэчулуун/, Нийслэлийн Эрүүл мэндийн газар /Л.Төмөрбаатар/, Нийслэлийн Онцгой байдлын газар /Л.Баярсайхан/, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар /Г.Баярсайхан/, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар /Ш.Цогбаатар/, Тээврийн Цагдаагийн албаны Замын Цагдаагийн газар /Д.Дашдорж/-т үүрэг болгосугай.

9. Халдвар хамгаалал, хорио цээр, хязгаарлалтын дэглэмийг баримтлан, үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад зөвлөсүгэй.

10. “Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр заавар”, “Зарим үйлчилгээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага”-ыг олон нийтэд мэдээлж, сурталчлах ажлыг зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга нар, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс /Б.Батманлай/-т үүрэг болгосугай.

11. Захирамжийн хэрэгжилтийг тухай бүр тайлагнаж ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад, хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлогын асуудал хариуцсан нэгдүгээр орлогч /Ж.Сандагсүрэн/-д даалгасугай.

12. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2020 оны А/1242, А/1251 дүгээр захирамжуудыг хүчингүй болсонд тооцсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Д.СУМЬЯАБАЗАР

Нийслэлийн Засаг даргын 2020 оны
12 дугаар сарын 11-ны өдрийн
А/Н/Б/О дүрсэр захирамжийн хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЬ ХЯЗГААРЛАХ САЛБАР, ЧИГЛЭЛ

№	Үйл ажиллагааны чиглэл
1.	Хүнсний болон ахуйн хэрэглээнээс бусад барааны худалдаа /бүх төрлийн хувцас, тавилга, гэр ахуйн бараа, цахилгаан бараа, бөс бараа, гоо сайхны бараа, тоглоом/
2.	Олон нийтийг хамарсан хурал, жагсаал, цуглаан, аялал зугаалга, тэмцээн уралдаан, хурим найр, цайллага, хүлээн авалт
3.	Бүх төрлийн баар /Диско, караоке, стриптиз, бильярд, паб -энгийн/
4.	Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа
5.	Цахим болон бүх төрлийн тоглоомын үйлчилгээ
6.	Спортын арга хэмжээ /цанын бааз, заал, бильярд, фитнес, бүжиг, иогийн клуб
7.	Саун, бассейн
8.	Шашны зан үйл /гандан, сүм хийд, мөргөлийн газрууд/
9.	Урлаг соёл, үзвэр үйлчилгээ
10.	Үсчин, гоо сайхан /гоо сайхан, хумс засал/
11.	Бариа засал, массажны газар, алжаал тайлах төв
12.	Амралт, жуулчны бааз, зочид буудал, дэн буудал
13.	Түргэн үйлчилгээний цэг
14.	Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны цэг
15.	Нийтийн халуун ус
16.	Дуудлагаар гэр цэвэрлэх үйлчилгээ
17.	Дүрс бичлэг
18.	5-аас дээш хүнтэй танхимын болон үйлдвэрлэлийн сургалт

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ДАРГА Д.СУМЬЯАБАЗАР

9020020910 9077073

2020 оны 12 дугаар сарын 11

ХЯЗГААРЛАЛТ ТОГТООХГҮЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНД МӨРДӨХ ХАЛДВАР ХАМГААЛЛЫН НИЙТЛЭГ ТҮР ЗААВАР

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед үйл ажиллагааг нь хязгаарлаагүй хуулийн этгээд Гамшгаас хамгаалах тухай, Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2020 оны 209 дүгээр тогтоол, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалаар баталсан “Коронавируст халдварын үед халдваргүйжүүлэлт хийх түр заавар” болон холбогдох журам, заавар, мэдэгдлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.2. Тусгай нөхцөл шаардах хүргэлтийн хоолны үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ /ресторан, кафе, түргэн үйлчилгээний болон сүлжээ хоолны газар, кофе шоп, цайны газар/, таксины үйлчилгээ эрхэлж буй үйл ажиллагааг нь хязгаарлаагүй хүн, хуулийн этгээд нь энэхүү заавар болон “Зарим үйлчилгээнд тавигдах тусгай нөхцөл шаардлага”-ыг мөрдлөг болгоно.

Хоёр. Үйл ажиллагааг нь хязгаарлаагүй хүн, хуулийн этгээдэд дараах нийтлэг шаардлага тавигдана:

2.1. Нийслэлийн Засаг даргын захирамжаар тогтоосон хугацааны хязгаарлалтад нийцүүлэн байгууллагын үйл ажиллагааны цагийн хуваарь баталж мөрдүүлэх;

2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, халдвар хамгааллын төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах;

2.3. Түр тусгаарлах өрөөг бэлтгэх, анхны тусламж үзүүлэх хайрцаг, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангах;

2.4. Баталгаат ундны усны эх үүсвэрээр хангагдсан байх;

2.5. Ажиллагсдыг нэгдсэн зохион байгуулалтаар байгууллагын унаагаар тээвэрлэх боломжийг бүрдүүлэх;

2.6. Байгууллагын хурал, семинар, олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд биечлэн оролцуулахгүй, зохион байгуулахгүй байх;

2.7. Үйл ажиллагаа эхлэхээс өмнө ахуйн шавьж, мэрэгч устгах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар халдваргүйжүүлэлт /хаяг, шошгогүй, хүчинтэй хугацаа дууссан, улсын бүртгэлд бүртгэгдээгүй бодисыг хэрэглэхгүй байх/ хийлгэсэн байх;

2.8. Байгууллагын ажиллагсад, түрээслэгчид болон үйлчлүүлэгчдийг хяналтын шугамаар нэвтрүүлж, гарыг халдваргүйжүүлэх, биеийн халууныг үзэх ажилтныг томилон тогтмол ажиллуулах, амны хаалтгүй хүнд үйлчлэхгүй байх;

2.9. Ажиллагсдыг ажлын байранд нэвтрэхээс өмнө биеийн халууныг хэмжиж амны хаалт зүүлгэн, гарыг халдваргүйжүүлэх, халдварт өвчтэй хүн асарсан, хавьтал болсон талаарх асуумжийг авч, бүртгэх;

2.10. Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх “Бүртгэлийн цэг”-ийн QR кодыг qr.119.mn сайтаас зааврын дагуу хэвлэн авч, иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулж, бүртгэлжүүлэх эсвэл qr.ulaanbaatar.mn сайтыг ашиглан зааврын дагуу үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхний QR кодыг байгууллагын албан хаагч уншуулж бүртгэлжүүлэх, хяналт тавих;

2.11. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг үйлчлүүлэгчдэд харагдахуйц ил тод байршуулах;

2.12. Монгол Улсын телехяналтын камерын техникийн ерөнхий шаардлага MNS 6423:2019 стандартын шаардлагыг хангасан хяналтын камертай байх;

2.13. Худалдаа үйлчилгээний газар нь үйлчлүүлэгч хоорондын зайг 2 метрээр тооцон улаан шугамаар тэмдэглэл хийж, орох, гарах хөдөлгөөнийг давхцуулахгүй зохион байгуулах;

2.14. Ажлын байр, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ариун цэврийн өрөө, угаалтуур, суултуур, шатны бариул, хаалганы бариул, цахилгаан шатны товчлуур, унтраалга, лангуу тавиур, ширээ сандал зэрэг хүний гар хүрэх бүх эд зүйлсийн гадаргууг 2 цаг тутамд цэвэрлэж, халдваргүйжүүлэх, заалны чийгтэй их цэвэрлэгээг өдөрт 3-аас доошгүй удаа хийх;

2.15. Үйлчлүүлэгчийн төлбөр тооцоог төлбөрийн карт, дансны дугаар ашиглан хийх, бэлэн мөнгөөр гүйлгээ хийхгүй байх, картыг ПОС машинаар уншуулах ба товчлуурыг тухай бүр халдваргүйжүүлэх уусмалаар арчих;

2.16. Өдөр тутмын цэвэрлэгээ, үйлчилгээ хийх үйлчлэгч нарыг ажлын хамгаалах хувцас, амны хаалт, бээлийгээр хангаж, цэвэрлэгээнд хэрэглэгдэх бодисыг найруулж бэлдэх, ашиглах зааварт сургаж, дадлагажуулсан байх;

2.17. Халдваргүйжүүлэх бодисыг сонгохдоо тусгай зөвшөөрөл бүхий ахуйн шавьж мэргэч устгах, ариутгал, халдваргүйжүүлэлтийн мэргэжлийн байгууллагаас аюулгүй ажиллагааны зааврын хамт авах /хаяг, шошгогүй, хүчинтэй хугацаа дууссан, улсын бүртгэлд бүртгэгдээгүй бодисыг хэрэглэхгүй байх/;

2.18. Хог хаягдлыг төрөлжүүлэн зориулалтын саванд цуглуулж тухай бүр зайлуулах, байгууллагын гадна орчны 50 метр хүртэлх орчныг цэвэрлэх;

2.19. Хяналтын шугамаар нэвтрэх үед үйлчлүүлэгчийн биеийн халуун 37.1 хэмээс дээш байх тохиолдолд байгууллагын удирдлагад яаралтай мэдэгдэж, Халдварт өвчин судлалын Үндэсний төвийн 100, 80086829, Зоонозын өвчин судлалын Үндэсний төвийн 70284393, Нийгмийн Эрүүл мэндийн төвийн 119 дугаарын утсаар яаралтай холбогдож, зөвлөгөө авах. Үйлчлүүлэгчээс коронавируст /ковид-19/ халдварт өвчтэй хүн асарсан, хавьтал болсон талаарх асуумжийг авч, бүртгэх;

2.20. Тухайн үйлчлүүлэгчийг эмнэлгийн байгууллагад шилжүүлсний дараа эцсийн ариутгал, халдваргүйтгэлийг хийлгэж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах.



2020 оны 12 дугаар сарын 11

ХООЛ ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАРТ ТАВИГДАХ ТУСГАЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газар /ресторан, кафе, түргэн үйлчилгээний болон сүлжээ хоолны газар, кофе шоп, цайны газар/ нь Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр заавар” болон энэхүү тусгай нөхцөлийн шаардлагыг мөрдөнө.

1. Үйлчилгээний танхимын суудлын тоог 30-50 хувиар цөөлөх, ширээ хоорондын зайг 2 м-ээр, 1 ширээнд 2 хүн суухаар тооцон ширээ, сандлыг байршуулах;

2. Үйлчлүүлэгч хоорондын зайг 1.5-2 метр байх нөхцөлийг бүрдүүлж, гадна хаалга болон үйлчилгээний танхимд “Манай байгууллага нэг удаад хүнд үйлчлэх хүчин чадалтай” гэсэн мэдээллийг байршуулах;

3. Сандал болон шалан дээр зай барих тэмдэглэгээг байршуулах /1 хүнд үйлчлэх талбайг 4 м²-аас багагүй байхаар тооцох/;

4. Шаардлагатай цэгүүдэд спиртэн суурьтай гар халдваргүйжүүлэх уусмалыг хүрэлцээтэй байршуулах /хяналтын шугам, иргэдийн үйлчлүүлэх цэг, ажиллагсдын орох хэсэг, ариун цэврийн өрөөл/;

5. Үйлчлүүлэгчийн төлбөр тооцоог төлбөрийн карт, гар утасны QRау, дансны дугаар ашиглан хийх, бэлэн мөнгөөр гүйлгээ хийхгүй байх, картыг ПОС машинаар уншуулсан тохиолдолд товчлуурыг тухай бүр халдваргүйжүүлэх уусмалаар арчих;

6. Олон нийтийг хамарсан арга хэмжээ, хүлээн авалт зохион байгуулахгүй байх;

7. Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх “Бүртгэлийн цэг”-ийн QR кодыг qr.119.mn сайтаас зааврын дагуу хэвлэн авч, иргэдийн орох хэсэгт ил харагдахаар байршуулж, бүртгэлжүүлэх эсвэл qr.ulaanbaatar.mn сайтыг ашиглан, зааврын дагуу үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхний QR кодыг байгууллагын албан хаагч уншуулж бүртгэлжүүлэх, хяналт тавих.

-оОо-



2020 оны 12 дугаар сарын 11

ХҮРГЭЛТИЙН ХООЛНЫ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ТУСГАЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Хүргэлтийн хоолны үйлчилгээ нь нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр заавар” болон энэхүү тусгай нөхцөлийн шаардлагыг мөрдөнө.

1. Ажил эхлэхээс өмнө ажлын байр, ажилчдын ахуй хангамжийн өрөө, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, халуун баригчтай зөөврийн сав, түгээлтийн тээврийн хэрэгслийг угааж цэвэрлэн, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж хэвших;


2. Хүргэлтийн хоолны ажилтныг хөдөлмөр хамгааллын хувцас, амны хаалт, нүүрний хаалт, нэг удаагийн бээлий, гар халдваргүйжүүлэх уусмалаар бүрэн хангах;

3. Хүргэлтийн хоолыг хүлээлгэн өгөхөд хүн хоорондын зайг баримтлан, гараас гарт дамжуулахаас зайлсхийх;

4. Үйлчлүүлэгчийн төлбөр тооцоог төлбөрийн карт, гар утасны QR-код, дансны дугаар ашиглан хийх, бэлэн мөнгөөр гүйлгээ хийхгүй байх, картыг ПОС машинаар уншуулсан тохиолдолд товчлуурыг тухай бүр халдваргүйжүүлэх уусмалаар арчих;

5. Захиалагчийн мэдээллийг бүртгэх “Бүртгэлийн цэг”-ийн QR кодыг үйлчлүүлэгчээр уншуулах, эсвэл хүргэлтийн ажилтан нь qr.uiaanbaatar.mn сайтыг ашиглан, зааврын дагуу үйлчлүүлэгчийн иргэний үнэмлэхний QR кодыг уншуулж бүртгэлжүүлэх.

-oOo-



ТАКСИ ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ ТУСГАЙ НӨХЦӨЛ ШААРДЛАГА

Такси үйлчилгээ нь нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагаанд мөрдөх халдвар хамгааллын нийтлэг түр заавар” болон энэхүү тусгай нөхцөлийн шаардлагыг мөрдөнө.

1. Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2011, Такси үйлчилгээ, Ерөнхий шаардлага MNS 5122:2013 стандартын шаардлагуудыг хангасан байх;

2. Үйлчилгээ эхлэхээс өмнө тээврийн хэрэгслийн гадна, дотор талыг угааж, халдваргүйжүүлэх;

3. Ажил эхлэхийн өмнө жолооч нарын биеийн халууныг хэмжиж, амны хаалт, нүүрний хаалт зүүлгэн, гарыг халдваргүйжүүлэх, халдварт өвчтэй хүн асарсан, хавьтал болсон талаарх асуумжийг авч, бүртгэх;

4. Таксины жолоочийн хэсгийг зорчигчдоос тусгаарлан хаалт /нийлэг хальсан материал ашиглаж болно/ хийж, зорчигчдыг зөвхөн арын суудалд суулгаж үйлчлэх;

5. Зөвхөн амны хаалттай зорчигчид үйлчлэх бөгөөд суудлын дэргэд гар халдваргүйжүүлэх уусмалыг байрлуулсан байх;

6. Зорчигчийг буулгаж дараагийн зорчигчийг суулгахаас өмнө тээврийн хэрэгслийн цонхыг 5-10 минут онгойлгон агаар сэлгэлт хийх, хаалганы бариул, суудал зэрэг хүний гар хүрэх бүх эд зүйлсийн гадаргууг халдваргүйжүүлэх бодисын уусмалаар шүршиж арчсаны дараа дараагийн зорчигчийг суулгах;

7. Үйлчлүүлэгчийн төлбөр тооцоог төлбөрийн карт, дансны дугаар ашиглан хийх, бэлэн мөнгөөр гүйлгээ хийхгүй байх, картыг ПОС машинаар уншуулсан тохиолдолд товчлуурыг тухай бүр халдваргүйжүүлэх уусмалаар арчих;

8. Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмжийг урд суудлын арын хэсэгт үйлчлүүлэгчдэд харагдахуйц ил тод байршуулах;

9. Иргэдийн зорчих хөдөлгөөний мэдээллийг бүртгэх “Бүртгэлийн цэг”-ийн QR кодыг qr.119.mn сайтаас зааврын дагуу хэвлэн авч, зорчигчоор уншуулах, эсвэл таксины жолооч нь qr.ulaanbaatar.mn сайтыг ашиглан, зааврын дагуу зорчигчийн иргэний үнэмлэхний QR кодыг уншуулж бүртгэлжүүлэх.